1.22.6.1	“Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласан.	Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна.	ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/88 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Хариуцлагатай газрын харилцаа” аян зохион байгуулах ажлын удирдамжийн хүрээнд тус газраас “Хариуцлагатай газрын харилцаа аяны ” хүрээнд 19 заалт бүхий төлөвлөгөөг гарган 13 сумын Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүлэн хамтран ажиллалаа. Аяны хүрээнд Баруун-Урт, Эрдэнэцагаан, Мөнххаан, Сүхбаатар, Дарьганга сумдын 112 аж ахуйн нэгж байгууллага, 273 иргэний нийт 385 нэгж талбарын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэх ажлыг хийж газрын төлбөрийн тооцоо нийлж, газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт баталгаажуулж, газар эзэмших эрх дуусгавар болсон 14 нэгж талбарын хугацааг сунгах, 2198 нэгж талбарын төлбөр, татварын нэхэмжлэх үүсгэн аяны хугацаанд аймгийн 192 аж ахуйн нэгж байгууллага, 120 иргэнтэй газрын төлбөрийн тооцоог бүрэн нийлж, газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт баталгаажуулах ажил хийгдсэн байна. Газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт 87,1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, Эрдэнэцагаан, Мөнххаан, Асгат, Онгон, Баруун-Урт, Халзан сумдын нийт өмчлөл, эзэмшил ашиглалтын 105 нэгж талбарыг Газрын кадастрын цахим мэдээллийн системд нөхөн бүртгэж ажлыг хийж, аймгийн хэмжээнд нийт 294 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд мэдэгдэх хуудас хэвлэн өгч үүнээс 180 нэгж талбарт захиалгат хянан баталгааг шинээр нэмж хийлгэсэн байна. Мөн аяны хүрээнд 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс Дарьганга, Мөнххаан, Түмэнцогт,	100

						Сүхбаатар, Онгон, Баяндэлгэр, Баруун-Урт сумдын нийт 1150 иргэнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар мэдээлэл сурталчилгааг хийж Газрын харилцааны салбар үүсч хөгжсөний 70 жилийн ой, “Газрын харилцааны ажилтан”-ны тохиолдуулан Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газартай хамтран спортын 5 төрөлт сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, шатар, даамны тэмцээнүүдийг Баруун-Урт суманд зохион байгуулалаа. Спортын 5 төрөлт арга хэмжээнд 13 сумын Засаг даргын тамгын газар, Аймгийн ЗДТГ-ын тамгын газар нийт 14 байгууллагын 415 албан хаагч хамрагдаж багийн дүнгээр Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газар тэргүүн байр эзэлсэн бол Аймгийн Засаг даргын тамгын газар 2 дугаар байр, Халзан сумын Засаг даргын тамгын газар 3 дугаар байрыг тус тус эзэллээ. Тус тэмцээний онцлог нь орон нутгийн анхан шатны байгууллагуудыг төрийн захиргааны албан хаагчдыг хамруулж газрын харилцааны салбарын онцлогийг таниулах, салбар дундын оролцоог хангах, хамтран ажиллах нөхцөл, ойлголцлыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой ажил байлаа. Тэмцээнд баг тамирчдаа бэлтгэн оролцсон 14 байгууллагад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас “Талархал” гардуулж газрын харилцааны салбарын хэмжээнд хийгдэж байгаа онцлог ажлуудын талаархи мэдээллийг хүргэж ажиллалаа. Аяны хүрээнд нийт албан хаагчид 5 чиглэлийн 28 төрлийн /постер/, 2 төрлийн контентыг үзүүлэн бэлтгэж албан ёсны пэйж хуудсараа дамжуулан 6040 иргэн, аж ахуй нэгжид хүргэж ажилласан байна. ГЗБГЗЗЕГ-аас газартай холбоотой гаргасан мэдээ мэдээллийг тухай бүрд нь пэйж хуудсандаа шейрлэж иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Мөн хэвлэмэл хуудсаар 410 иргэнд гарын авлага тарааж орон нутгийн BBS телевиз, SB info цахим сайтад 3 удаагийн мэдээлэл өгч 3250 орчим иргэнд мэдээлэл нь хүрсэн байна. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хууль тогтоомж сурталчлах, мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах үүднээс нийт 8 удаа 20 сэдвийн хүрээнд	
--	--	--	--	--	--	---	--

						зохион байгуулж 121 аж ахуйн нэгж 1550 иргэн, төрийн байгууллагын 152 албан хаагчийг хамруулсан байна. Мөн ГЗБГЗЗЕгазраас зохион байгуулсан спортын тэмцээнд Зүүн бүсийн аймгуудтай хамтран оролцож байгууллагын 5 албан хаагчийг тэмцээний бэлтгэлд гарган амжилттай оролцсон. Аяны хүрээнд хийсэн ажлын тайланг ГЗБГЗЗЕГ-т хугацаанд хүргүүлсэн болно.	
--	--	--	--	--	--	--	--

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
2.1.2	Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ	Үйл ажиллагаа	Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн сангийн цахим үйлчилгээгээр хэрэглэгч байгууллага, иргэдийг хангах	Байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг хөтлөх журам батлагдсан. Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн санг цахимаар шинэчлэх боломж бүрдсэн.	21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.		
2.1.2.1	Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах	Үйл ажиллагаа	Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоо	2023 онд ААН-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр АМХ-д хүлээлгэн өгсөн.	Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг хүлээн авч геопорталд мэдээллийг оруулж, хэрэглээнд гаргасан байна.	Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хөрөнгөөр хийгдсэн нийт 20 бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн зургийг MNS6702:2017 стандартын дагуу гүйцэтгүүлэн шалгаж хүлээн авч аймгийн архивт актаар хүлээлгэн өгсөн. Мөн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/241 тоот албан бичгийн хавсралтаар ГЗБГЗЗГ-т гүйцэтгэлийн зураг, мэдээллийн сан хөтөлсөн тайлан, ажил шалгаж хүлээн авсан актуудыг	100

						хүргүүлэн ажилласан. 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн зураг, мэдээллийн сан хөтөлсөн тайлан, ажил шалгаж хүлээн авсан актуудыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор ГЗБГЗЗЕГ-н архивт хүлээлгэн өгнө. 2024 оны 06 дугаар сараас эхлэн хот байгуулалтын цахим систем бүрэн ашиглалтад орсон тул Сүхбаатар аймагт шинээр ашиглалтад орж буй барилга, байгууламж, шугам сүлжээний тоон мэдээллийг urban.gov.mn цахим системд бүртгэж холбогдох мэдээллүүдийг оруулан QR код бүхий гүйцэтгэлийн зураг хүлээн авсан актыг тухай бүр Хот байгуулалтын цахим системээс гарган ажилласан.	
2.1.3	Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	1 систем	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн хэвийн ажиллагааг хангасан байна. Ази-Номхон далайн бүсийн геодезийн ажлын группд Монгол Улсын 6 GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын хэмжилтийн өгөгдлийг бэлтгэн илгээсэн байна.		
2.1.3.1	Геодезийн сүлжээний цэгийн солбицлыг ITRF2020 солбицлын тогтолцоонд	Үйл ажиллагаа	1 цэг	Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор ITRF2020 солбицлын	Эхний хагас жилд: Аймгийн төвд байрлах гравиметрийн сүлжээний цэг дээр GNSS-ийн 12 цагийн	Монгол улс ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжиж буйтай холбоотойгоор GNSS-ын байнгын ажиллагаатай станцуудыг шинэ эринд тэгшитгэн бодох, алдааг бууруулах ажил хийгдэж байгаа	100

	шилжүүлэх судалгаа хийх			тогтолцоог ашиглахаар болсон.	хэмжилт хийж өгөгдлийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	билээ. Энэ ажлын хүрээнд аймгийн төвд байрлах СҮА-1 байнгын ажиллагаатай станцын бодит агшны хяналтын хэмжилтийг 1 дүгээр сарын 23-ны өдөр ГЦТ5338 цэг дээр хийж үр дүнг <u>\\192.168.20.24\Geodesy\GNSS хяналт хэмжилт2024\Сүхбаатар</u> серверт байршуулсан. Аймгийн төвд байрлах GNSS-ийн сүлжээний ГЦТ5338 цэг дээр 05 дугаар сарын 31-ний өдрийн 08 ⁰⁰ цагаас 20 ⁰⁰ цаг хүртэл 12 цагийн статик хэмжилт хийсэн. Хэмжилтийн үр дүн болон журналыг <u>\\192.168.20.24\Geodesy\Отгонбаяр\12цаг Статик\Сүхбаатар12цаг</u> серверт байршуулсан.	
2.1.5	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх	Үйл ажиллагаа	GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээ 200 цэг, тэмдэг	Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.	Цэг, тэмдэгтийн цахим санг хөтөлж, шаардлагатай цэг, тэмдэгтийг нөхөн сэргээсэн байна.		
2.1.5.1	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх	Үйл ажиллагаа	GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний цэг, тэмдэгт	Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2023 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.	Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.	Сүхбаатар аймгийн хэмжээнд шинээр нэмэгдсэн 2 цэгийн мэдээллийг шинээр оруулж, зөрүүтэй бүртгэгдсэн 10 цэгийн мэдээллийг засварласан байна.	100
2.1.5.2	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Нөхөн сэргээсэн цэгийн тоо	2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх” журмыг баталсан.	Цэг, тэмдэгт нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээн авч, цэг, тэмдэгтийн мэдээллийг цахим санд оруулсан байна.	Дарьганга сумын төвд байрлах ГЦТ6789 цэг нь айлын хашааны үүдэнд гэмтэх эрсдэлтэй газарт байрладаг ба тус цэгийг гэмтээхээс хамгаалж 1.5м:1.5м-ийн харьцаатай, 1.2 м-ийн өндөртэй төмөр сараалжин хашаагаар хашаалж гэмтэх эрсдлээс бүрэн хамгаалсан. Мөн тус цэг дээр хяналтын хэмжилт хийн зурагжуулж үр дүнг nsdi.gov.mn цахим системд оруулсан. Мөн сумдын төвд байрлах 64 цэг	100

						тэмдэгт хөдөө байрлах 2 цэгийн тооллогыг хийн цахим санд бүртгэн, канавыг засварлан сэргээсэн.	
2.1.6	Хаягийн мэдээллийн системийг хөтлөх	Үйл ажиллагаа	Хаягийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа	Хаягийн мэдээллийн санг нэвтрүүлсэн.	Хаягийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.		
2.1.6.1	Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх	Үйл ажиллагаа	Гудамж, замын тоо	Хаягийн мэдээллийн систем	Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг аймгийн ерөнхий архитектортай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, нэр олгогдсон, нэрэмжит болгосон талбай, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна.	Хаягийн мэдээллийн системд нэр хаяг олгогдоогүй гудамж, зам талбайд нэр өгөх ажлыг гүйцэтгэхээр орон нутгийн төсөвт 100 сая/ төгрөгийг Баруун-Урт суманд тусгуулсан боловч Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн ерөнхий газраас 2024.06.27-ны өдрийн 2/1655 тоот чиглэл ирүүлсэний дагуу хаягийн мэдээллийн нэгдсэн системд шинэчлэх ажил хийгдэж, хаяг олгох үйл ажиллагаа автоматжуулах, цахимжуулах ажил хийгдэж байгаатай холбоотой тухайн ажлыг түр зогссон. Эрхийн шилжилт хөдөлгөөн болон хэсэгчлэн шилжүүлэх, хуваах нэгтгэх нэгж талбарт хаяг олгох үйл ажиллагаа Монгол Улсын засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын дагуу гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягжуулалт журамын 6.10, 6.13 дах хэсэгт заасны дагуу шийдвэрлэн мэдээллийн санд бүртгэн баталгаажуулан ажил хийгдэж байна. Үүнд: Сүхбаатар сум 2023 онд 11 сая/төгрөг тусган гүйцэтгэгч Гангачуулган ХХКомпани 2024 онд хаяг тэмдэгжүүлэлтийн ажлыг 100 гүйцэтгэлтэй хийж хүлээлгэн өгссөн. Түмэнцогт сумын хаягийн ажил орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15 сая төгрөг тусган шууд гэрээгээр гүйцтгэн уг ажлыг хийж гүйцэтгэсэн.	100
2.1.6.2	Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй боловч хаяг олгогдоогүй нэгж талбарт Хаягийн мэдээллийн системээр хаяг олгож,	Үйл ажиллагаа	Гудамж, замын тоо	Хаягийн мэдээллийн систем	Хаяг олгогдоогүй нэгж талбаруудад хаяг олгож баталгаажуулсан байна	Хаягийн мэдээллийн системд нэр хаяг олгогдоогүй гудамж, зам талбайд нэр өгөх ажлыг гүйцэтгэхээр орон нутгийн төсөвт 100 сая/ төгрөгийг Баруун-Урт суманд тусгуулсан боловч Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн ерөнхий газраас 2024.06.27-ны өдрийн 2/1655 тоот чиглэл ирүүлсэний дагуу хаягийн мэдээллийн нэгдсэн системд шинэчлэх	90

	баталгаажуулах, тус системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглах					ажил хийгдэж, хаяг олгох үйл ажиллагаа автоматжуулах, цахимжуулах ажил хийгдэж байгаатай холбоотой тухайн ажлыг түр зогссон. Эрхийн шилжилт хөдөлгөөн болон хэсэгчлэн шилжүүлэх, хуваах нэгтгэх нэгж талбарт хаяг олгох үйл ажиллагаа Монгол Улсын засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын дагуу гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягжуулалт журамын 6.10, 6.13 дах хэсэгт заасны дагуу шийдвэрлэн мэдээллийн санд бүртгэн баталгаажуулан ажил хийгдэж байна. Үүнд: Сүхбаатар сум 2023 онд 11 сая/төгрөг тусган гүйцэтгэгч Гангачуулган ХХКомпани 2024 онд хаяг тэмдэгжүүлэлтийн ажлыг 100 гүйцэтгэлтэй хийж хүлээлгэн өгссөн. Түмэнцогт сумын хаягийн ажил орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15 сая төгрөг тусган шууд гэрээгээр гүйцтгэн уг ажлыг хийж гүйцэтгэсэн. Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй боловч хаяг олгогдоогүй 10 нэгж талбарт хаягийн мэдээллийн системээр хаяг олгон баталгаажуулсан.	
2.1.6.3	Хаягийн өгөгдөл мэдээллийг засварлах, шинэчлэн зураглах ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээг засварлах	Үйл ажиллагаа	Зам, гудамж, орц гарц, гудамжны эхлэл, төгсгөлийн тоо	Хаягийн мэдээллийн систем	Жилийн эцэст: Батлагдсан ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээллийг засварласан байна.	2024 онд хаягийн өргөдөл мэдээллийг засварлах шинэчлэн зураглах зам гудамж орц гарцны эхлэл төгсөлийн тоо гэх суурин ажиллагаа болон орон нутгийн төсөвт шинээр хаягжуулалт хийлгүүлэхээр 100 сая/ төрөг тусган ажилласан боловч хаягийн шинэчлэх ажил хийгдэж байгаатай холбоотойгоор Баруун-Урт суманд зогсоогдсон. Түмэнцогт болон Сүхбаатар сумын хэмжээнд хаягжуулалт хийгдэн хаягийн мэдээллийн санд өргөдөл мэдээллийг оруулан тэмдэгжүүлэлтийн ажил хийгдсэн.	100
2.1.7	Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих	Үйл ажиллагаа, ургалт төсөв	Нийслэл, 21 аймаг	Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржийн системийг нэвтрүүлсэн.	Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.		

2.1.7.1	Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн, системээс төлөлтийн мэдээлэл хүлээн авсан нэгж талбарын тоо	Газрын төлбөр, татварын систем	Хуульд заасан хугацаанд төлбөр, татварын ногдуулалтыг илгээх, төлөлтийн мэдээллийг тухай бүр хүлээж авсан байна.	2024 онд газрын кадастрын цахим системд 2346 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт хийгдсэнээс 2290 нэгж талбарт газрын төлбөрийн нэхэмжлэх үүсгэж харъяалах татварын хэлтэст хуулийн хугацаанд нь илгээсэн. Газрын төлбөрийн нэхэмжлэхийг 97.6 хувьтай үүсгэж харъяалах Татварын хэлтэст илгээсэн. 12 дугаар сарын 1-ний байдлаар газрын кадастрын цахим системд 2346 нэгж талбарт 508590.2 мянган төгрөгийн газрын төлбөр бодит ногдуулалт хийгдсэн. Энэ онд газрын төлбөрийн орлогоос аймгийн хэмжээнд 447551.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар 470072.3 мянган төгрөгийн орлогыг сум орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Газрын төлбөрийн орлого 105.8 хувийн биелэлттэй байна. Асгат, Баруун-Урт, Дарьганга, Мөнххаан, Түмэнцогт, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 2024 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг бодит бусаар хэт өндөр төлөвлөсөн учраас 7-н сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн санд аймгийн ГХБХБГазрын даргын 2024 оны 1/234, 1/235, 1/236, 1/237, 1/238, 1/239, 1/240 тоот албан бичгийг тус тус хүргүүлж тухайн сумд төсөвтөө тодотгол хийсэн. Газрын кадастрын цахим системд 8583 иргэнд татварын ногдуулалт хийгдэж 8156 иргэнд газрын татварын нэхэмжлэх үүссэн байна. Газрын татварын нэхэмжлэх 95 хувьтай үүссэн байна. Одоогийн байдлаар газрын татвараас 380.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрсөн.	100
2.1.7.2	Төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд	Үйл ажиллагаа	Эрхийн харилцаанд орж байгаа нэгж талбарын тоо	Газрын төлбөр, татварын систем	Үйлчилгээ үзүүлсэн тоогоор тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна.	Газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалсан бүртгэл газрын кадастрын цахим системд 8-н суманд 132 хийгдэж орон нутгийн төсөвт 1320.0 мянган төгрөг, газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны бүртгэл 4-н суманд 76 хийгдэж тэмдэгтийн хураамжаас төсөвт 950.0 мянган төгрөг, газар эзэмших эрхийн төсөл сонгон шалгаруулалтын	100

	илгээх ажлыг зохион байгуулах					бүртгэл 4-н суманд 38 хийгдэж 475.0 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрүүлсэн. Аймгийн төрийн санд нийт 2745.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.	
2.1.7.3	Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах	Үйл ажиллагаа	Цахим системийн хэрэглээ	Газрын төлбөр, татварын систем	Эхний хагас жилд: Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжийг сурталчилсан байна.	Энэ онд тус газраас газрын харилцааны чиглэлийн үйлчилгээ авч байгаа бүх иргэдэд egazar.gov.mn, газрын биржийн цахим систем mle.mn сайтуудыг ашиглан газар эзэмших гэрчилгээ, гэрээ, кадастр хэвлэх газрын төлбөр, татварын төлөлт хийх, нэгж талбарын тодорхойлолт, газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт, барьцааны лавлагаа хэрхэн хэвлэх, энэ оноос шинээр газар эзэмших өргөдлийг цахимаар хүлээн авч байгаатай холбогдуулан 210 гаруй иргэн, аж ахуйн нэгжид заавар, зөвлөмж өгч ажилласан.	100
2.1.7.4	Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд оруулах, масс үнэлгээ хийх	Үйл ажиллагаа	Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо	Газрын үнэлгээний систем	Эхний хагас жилд: Хот, тосгон, бусад суурин газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна. Жилийн эцэст: Бүртгэсэн зах зээлийн үнийн мэдээллийг ашиглан масс үнэлгээ хийсэн байна.	Энэ оны 12 дугаар сарын 01-ний байдлаар Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Сүхбаатар, Халзан сумдад 131 нэгж талбарын газрын зах зээлийн үнийн мэдээг газрын биржийн цахим системд бүртгэж газрын үнэлгээний системд оруулж масс үнэлгээ хийгдсэн. Үүний 21 нэгж талбар нь үл хөдлөх хөрөнгө бүхий газар бүртгэгдсэн.	100
2.1.7.5	Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан	Үйл ажиллагаа	Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо	Газрын үнэлгээний систем	Эхний хагас жилд: Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг	Онгон суманд иргэн, хуулийн этгээдэд олгогдсон эзэмшил газарт дуудлага худалдааны анхны үнэ 84.0 мянган төгрөг, Эрдэнэцагаан суманд 2565.0 мянган төгрөгийг газрын дуудлага худалдааны 100120000967 тоот дансанд тус тус төлүүлсэн ба Сүхбаатар суманд газрыг нөхөх олговортойгоор солихоор 2 байршлыг энэ оны ГЗБТ-нд тусгасан. Газар чөлөөлөлтийг 7 дугаар сард хийж дуусгасан. Сумын төрийн сангаас нөхөн олговорт зориулж 105000.0 мянган төгрөг гаргаж өгсөн байна.	100

	боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх;				цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.		
2.1.7.6	Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо	Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн.	Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газарт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байна.	Энэ оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 11 сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 115 байршлын газрын дуудлага худалдаа төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар газрын биржийн цахим системээр Сүхбаатар, Халзан сумдад нийт зохион байгуулагдсан 6-н байршлын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж орон нутгийн төсөвт 67183.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байгаа ба 6-н суманд 12 дугаар сарын 03-наас 12 дугаар сарын 30-ний хооронд 67 байршлын газар эзэмших эрхийн дуудлага худалдаа зарлагдсан. Эдгээр дуудлага худалдаанаас орон нутгийн төсөвт 1.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх зорилт тавин ажиллаж байна. Мөн оны 2 дугаар улиралд Газрын тухай хуулийн 33.1.2, 33.5-д орсон нэмэлт өөрчлөлт орж, монгол улсын Засгийн газрын 166, 187 дугаар тогтоолууд батлагдан гарсантай холбоотойгоор Дарьгангад 8, Мөнххаанд 57, Сүхбаатарт 17, Халзанд 10 аймгийн хэмжээнд нийт 92 нэгж талбарын газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалтууд төлөвлөгдсөн. Үүнээс 28 байршлын төсөл сонгон шалгаруулалт амжилттай зохион байгуулсан бөгөөд Мөнххаан, Халзан суманд 50-н байршлын төсөл сонгон шалгаруулалтуудыг энэ онд багтаан дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна.	100

2.1.7.7	Газрын биржийн цахим програм хангамжаар дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх	Үйл ажиллагаа	Эрх шилжсэн нэгж талбарын тоогоор үнийн мэдээ нэмж бүртгэнэ.	Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх боломжтой болсон.	Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна.	Энэ оны 12 дугаар сарын 01-ний байдлаар Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Сүхбаатар, Халзан сумдад 131 нэгж талбарын газрын зах зээлийн үнийн мэдээг газрын биржийн цахим системд бүртгэж газрын үнэлгээний системд оруулж масс үнэлгээ хийгдсэн. Худалдагдсан газруудын мэдээллийг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийдэг “Линзийн өгөөж” ХХК-д компанид хүргүүлэн харилцан мэдээлэл солилцож ажилласан.	100
2.1.8	Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих	Үйл ажиллагаа	Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа	Газрын кадастрын мэдээллийн санг нэвтрүүлсэн.	Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.		
2.1.8.1	Сумдын газрын даамлуудын өмнөх онуудад үүсгэсэн нэгж талбарын хувийн хэрэгт хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нөхөн бүрдүүлэх, цэгцлэх, ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Засвардлагдсан нэгж талбарын хувийн хэргийн тоо	Нэгж талбарын хувийн хэргийн тоо	Нэгж талбарын хувийн хэрэгт холбогдох журмын дагуу хяналт хийгдэж алдаа, дутагдал заварлагдаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/284 тоот албан бичгийн хүрээнд Эрдэнэцагаан,Түмэнцогт сумын сумын засаг даргын захирамжаар 2003 оноос 2023 оны хооронд иргэн, хуулийн этгээдэд олгосон газарт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд байгууллагын газрын даргаар төлөвлөгөө, удирдамж, ажлын хэсэг байгуулж хяналт шалгалтанд бэлтгэн Түмэнцогт, Эрдэнэцагаан 2 суманд хяналт шалгалт хийн ажилласан. Шалгалтын мөрөөр Эрдэнэцагаан суманд эзэмшлээр олгогдсон 119 нэгж талбар, ашиглалтын 4 нэгж талбарын хувийн хэргийг цэгцлэн архивласан.Мөн 2003-2012 онд иргэнд өмчлүүлсэн газруудын цаасан хувийн хэргийг ангилан цэгцэлж захирамжийн дараалалд оруулсан. 2013 оноос хойш олгогдсон нэгж талбаруудыг Газрын кадастрын системд орсон болон нөхөн орохоор ялгаж, давхардуулан өгсөн иргэдийн өргөдлийг холбогдох хувийн хэрэгт хавсаргах, нэгтгэх ажлыг зохион байгуулсан. 2023-2024 онд нөхөн бүрдүүлэлт хийсэн өмчлөлийн 67, ашиглалтын 1, эзэмшлийн 1 нэгж талбарын цаасан болон цахим хувийн хэргийг	100

						үүсгэн, иргэдэд газрын гэрчилгээ авахад шаардлагатай баримт материалаар үйлчилсэн. Халзан суманд 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэрийг ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн маягтын дагуу бүртгэсэн. Газар эзэмшлээр 130, газар өмчлөлөөр 244 шийдвэр бүртгэгдсэн. Уг бүртгэлээр нэг иргэнд давхардуулан 2-3 удаа өмчлөх захирамж гаргасан зөрчлүүд илэрсэн. Судалгааны ажил 90 хувьтай үргэлжилж байна. Дээрхи Эрдэнэцагаан, Түмэнцогт суманд хяналт шалгалтын мөрөөр зөрчил арилгасан ажлын тайланг ГЗБГЗЗЕГ газарт хүргүүлэн ажилласан. Үлдсэн сумдын зөрчил арилгах арга хэмжээ явагдаж байгаа бөгөөд тайланг оны эцэст хүргүүлнэ.	
2.1.8.2	Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн цахим архивын материалд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийн дагуу цахим хавсралтыг баяжуулах арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Засварлаж сайжруулсан цахим хавсралтын тоо	Системд бүртгэгдсэн өргөдлийн тоо	ГКМС-ийн өргөдлийн цахим хавсралтад хяналт шалгалт хийгдэж алдаа дутагдал засварлагдаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	ГЗБГЗЗЕГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/284 тоот албан бичгийн хүрээнд Эрдэнэцагаан, Түмэнцогт сумын засаг даргын захирамжаар 2003 оноос 2023 оны хооронд иргэн, хуулийн этгээдэд олгосон газарт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд байгууллагын газрын даргаар төлөвлөгөө, удирдамж, ажлын хэсэг байгуулж хяналт шалгалтанд бэлтгэн дээрхи 2 сумын нэгж талбарын цаасан хувийн хэргийг сканардан цахим архив үүсгэж газрын кадастрын мэдээллийн санд хавсарган оруулсан. Үүнд: Түмэнцогт суманд эзэмшилээр олгогдсон 289 нэгж талбарт ашиглалтаар олгогдсон 7 нэгж талбарт, өмчлөлөөр 815 нэгж талбараас сонгон хяналт шалгалт хийсэн ажлын мөрөөр дээрхи нэгж талбаруудын цаасан хувийн хэргийг цэгцэлж цахим архив үүсгэн скандаж тоон хэлбэрт хөрвүүлсэн. Үүнээс: 852 өргөдлийн цахим хавсралтыг засварлаж оруулсан байна. Эрдэнэцагаан суманд эзэмшлээр олгогдсон 119 нэгж талбар, ашиглалтын 4 нэгж талбарын хувийн хэргийг цэгцлэн цахимжуулж, Газрын кадастрын мэдээллийн системд холбогдох хавсралтуудыг оруулсан. Бусад сумдын газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн нэгж талбарын хувийн хэргийн цахим	100

						хавсралт оруулах ажил үе шаттайгаар хийгдэж байна. оны эцэст тайланг ГЗБГЗЗЕГазарт хүргүүлнэ. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг ерөнхий газар ерөнхий газраас 2014 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/1234 дугаартай “Удирдамж хүргүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн ГЗБГЗЗЕГ-ын даргын баталсан 35-00/08 дугаартай “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжуудын дагуу Баруун-Урт, Дарьганга, Онгон, Сүхбаатар, Асгат, Наран, Баяндэлгэр, Мөнххаан, Халзан, Түмэнцогт, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумдад газар эзэмшиж байгаа 185 нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдэлтэд газрын удирдлагын цахим системээр хяналт шалгалт ажил хийгдэж байна. Үүнд: 1.Эрдэнэцагаан сумын Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн нэгж талбарын хавсралт буруу оруулсан өргөдлийг засварлах чиглэлийн дагуу 8 нэгж талбарын 19 өргөдлийн хавсралтын хянан буруу, зөрүүтэй оруулсан 14 ш хавсралтыг устган, хувийн хэрэгт байгаа ч системд бүртгэгдээгүй нийт 41 ш хавсралтыг холбогдох өргөдөлд хавсарган засварлаж зөрчлийг арилгасан байна.	
2.1.8.3	Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулах, орон нутагт цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Газрын нэгдсэн цахим систем /egazar.gov.mn/	Цахим системийн хэрэглээ нэмэгдэж иргэд олон нийт Egazar.gov.mn хаягаас газартай холбоотой мэдээ, мэдээлэл авах, цахимаар хүсэлт илгээдэг болж цахимаар илгээх хүсэлтийн тоог нэмэгдүүлсэн байна	Газрын нэгдсэн цахим систем болох egazar.gov.mn-р дамжуулан иргэдийн цахим хүсэлтүүдийг хэрхэн илгээх талаар мэдээллийг иргэд Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албаны пэйж хуудсаар дамжуулан хүргэж ажиллаж байна мөн иргэдэд ажлын байран дээр ирж үйлчилгээ авахад заавар зөвлөгөө өгч ажиллаа. egazar.gov.mn сайтаар дамжуулан газрын нэгдсэн цахим системээр нийт 1655 цахим хүсэлт ирсэн байна. Аймгийн прокурорын газрын хүсэлтээр тус байгууллагын 14 албан хаагчдад egazar.gov.mn болон mle.mn цахим систем ашиглаж газартай холбоотой мэдээ, мэдээлэл авах, цахимаар хүсэлт илгээх, батлагдсан төлөвлөгөөг харах, санал өгөх, газрын төлбөрийг цахимаар төлөх, дуудлага худалдаатай холбоотой зар мэдээллийг авах,	100

						оролцох талаар танилцуулгыг тухайн байгууллагын албан газарт очиж хийсэн.	
2.1.8.4	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо	Газрын кадастрын мэдээллийн санд нийт бүртгэсэн өргөдөл	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан байна.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч нийт 1655 өргөдөл ирж 666 хүсэлтийг шийдвэрлэсэн. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 989 цахим хүсэлт ирсэн. Үүний тухайн жилийн ГЗБ төлөвлөгөөнд 14 нэгж талбар төлөвлөгдсөний дагуу www.egazar.gov.mn цахимаар явц 5 дээр 12 нэгж талбар дээр журмын дагуу олголт хийгдсэн засаг даргын захирамжаар баталгаажуулсан.	100
2.1.8.5	Нийт сумдын 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах	Үйл ажиллагаа	Захирамжийн тоо, нөхөн бүртгэж оруулсан нэгж талбарын тоо	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй нэгж талбарын тоо	Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргасан байна. ГКС-д нөхөн бүртгэх арга хэмжээ бүрэн дууссан байна.	ГЗБГЗЗЕГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/284 тоот албан бичгийн хүрээнд Эрдэнэцагаан сумын засаг даргын захирамжаар 2003 оноос 2023 оны хооронд иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын судалгааг гаргасан. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй 133 нэгж талбарыг нөхөн оруулсан. Үүнд: Эрдэнэцагаан суманд олгогдсон нэгж талбаруудын хувийн хэргийг Газрын удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн эсэхийг ялган нөхөн бүрдүүлэлтээр орох 112 иргэний өргөдөл, холбогдох материалыг сканнердан цахим файл үүсгэсэн. Үүнээс байршил тодорхой, бичиг баримтийн бүрдэл хангасан 87 нэгж талбарыг Газрын кадастрын цахим мэдээллийн системд нөхөн	100

						бүртгэж цахим болон цаасан хувийн хэрэг үүсгэсэн байна. Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 1 ашиглалтын нэгж талбар, 1 эзэмшлийн нэгж талбарыг нөхөн бүрдүүлсэн байна. ГЗБГЗЗЕГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/284 тоот албан бичгийн хүрээнд Эрдэнэцагаан сумын засаг даргын захирамжаар 2003 оноос 2023 оны хооронд иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын судалгааг гаргасан. - Өмчлөл нийт 1693 иргэн - Эзэмшил нийт 351 иргэн, ААНБ - Ашиглалт нийт 99 иргэн, ААНБ-д олгосон газрын дэлгэрэнгүй судалгааг гарган 2024 оны 03 дугаар сарын 15-нд эцсийн байдлаар ГЗБГЗЗЕГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. 2003-2012 он хүртэлх захирамжийг аймгийн архиваас шүүж байхгүй захирамжийг хуулбар үнэн даруулан авсан. Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдын нийт захирамжийн товъёог үйлдэн он оноор нь сканердан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Улсын тусгай хэрэгцээний газартай давхацсан болон Бичигт боомтод байршилтай 7 иргэн, ААНБ-аас ирүүлсэн нөхөн бүрдүүлэлт хийлгэх хүсэлт, судалгааг холбогдох хувийн хэргийн хамт хянуулахаар ГЗБГЗЗЕГ-руу хүргүүлсэн. Бүх сумдууд 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр нэг бүрчлэн бүртгэж маягтын дагуу гаргаж ГКС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж нотлох баримтыг үндэслэн нэгж талбарыг ГКС-нд нөхөн оруулаад байна. Үүнд Асгалт-1, Баяндэлгэр-3 нэгж талбар, Баруун-Урт-30, Халзан-3 онгон-1, сүхбаатар сум-7, Эрдэнэцагаан-87 нийт 133 нөхөн оруулсан. судалгааны дагуу Эрдэнэцагаан, Баруун-Урт нөхөн бүрдүүлэлт дуусаагүй.	
2.1.8.6	Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг	Орон нутгийн төсөв	Аймаг, сумдад шинээр нэвтрүүлсэн	Улсын хэмжээнд 2022 оноос эхлэн нийт 21	Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой	Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн	100

	зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх		төхөөрөмжийн тоо	төхөөрөмжийг нэвтрүүлсэн.	үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна.	шуурхай хүргэх үүднээс Баруун-Урт сумын үйлчилгээний нэгдсэн цэг байршуулж иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 150-200 иргэн үйлчлүүлж газартай холбоотой лавлагаа мэдээлэл авч ажилласан байна.	
2.1.8.7	Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээнээс төлбөр тооцох боломжийг бүрдүүлж холбогдох байгууллагатай гэрээ байгуулж ажиллах	Үйл ажиллагаа	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээ	2023 онд төлбөр тооцох хөгжүүлэлтийг гүйцэтгсэн.	Холбогдох байгууллагатай гэрээ байгуулж Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээ төлбөртэй болсон байна.	Харилцагчийн үйлчилгээний төлбөр тооцооны ажлыг хялбаршуулах ажлын хүрээнд ККТТ-тай хамтран Харилцагч нарт киоск машинаас үзүүлж буй үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх, тогтвортой ажиллуулах, үүнтэй холбоотойгоор үүсэх асуудлыг зохицуулах үүднээс гэрээг байгуулж Иргэд киоск машинаар үйлчилгээ авахад Qraу уншуулан тодорхой хэмжээний төлбөрийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлдэг болсон.	100
2.1.8.8	Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, өгөгдөл, мэдээлэл, цахим хавсралтыг үнэн зөв бүрдүүлж ажиллах	Үйл ажиллагаа	Системийн хэвийн үйл ажиллагаа	Газрын кадастрын мэдээллийн систем	ГКМС-ийг холбогдох журам, зааврын дагуу өгөгдөл мэдээллийг үнэн зөв бүртгэж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.	Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, өгөгдөл, мэдээлэл, цахим хавсралтыг үнэн зөвийг шалгаж буруу орсон нэгж талбаруудыг үнэн зөвөөр засуулах тал дээр анхааран даамлуудад мэргэжил арга зүйн чиглэл өгч ажиллаж байна.	100
2.1.8.9	ГКМС-д бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж буруу, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах, сайжруулах, шинээр ОНТХ-нд авсан газрыг бүртгэж баталгаажуулах	Үйл ажиллагаа	Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо	-	Жилийн эцэст: Аймаг, сумдын хэмжээнд ОНТХ-нд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн судалгааг гаргаж ГКМС-д бүртгэгдсэн мэдээлэлд нэг бүрчлэн хяналт хийж, илэрсэн алдаа дутагдлыг засварласан байна. Шинээр авсан газрыг	Аймаг сумын хэмжээнд Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн судалгааг байгаль орчины аялал жуулчлалын газраас судалгааг гаргуулан газрын кадастрын цахим системд мэдээллийг бүртгэн зурагжуулан баталгаажуулсан. Үүнд Баяндэлгэр сумын орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай 2013 оны 02 дугаар сарын 04 өдрийн 04 тоот тогтоолоор доорхи 4 байршил 1. “Хонгорын ухаа” түүхийн дурсгалт газар тахилгатай овоо, 25566,5782га газрыг орон нутгийн тусгай хамгаалтанд авсан. 2. Өгөөмөрийн хийд туурь сумын тусгай хамгаалалтанд авах 152921,1085 га	90

					кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулсан байна.	3. Ямаатын айраг сумын тусгай хамгаалалтанд авах 51788,4072 га 2004 оны 01 дүгээр сарын 04 өдрийн 04 тоот тогтоолоор Онгон таван булгийг эх орчны 1500 га, байшингийн шал 500га улсын тусгай хамгаалтанд орсон газруудыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. 2016 оны 04 дүгээр сарын 25 өдрийн 6 дугаар сарын тогтоолоор 186 түүх соёл үл хөдлөх, дургалт газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг ГКС-д бүртгэн оруулах гэсэн боловч солбилцол нь цэгээр 186 оруулсан тул цахим ситемд оруулах боломжгүй байгаа алдаа дутагдалууд гарсан тул сүхбаатар аймгийн байгаль орчны газартай хамтран үлдсэн нэгж талбаруудыг 2025 онд ОНТХ-нд авсан газруудын хэмжилтийг үндэслэн газрын кадастрын мэдээллийн санд оруулахаар бэлтгэн ажиллаж байна.	
2.1.8.10	Газрын нэгдмэл сангийн цахим системийн өгөгдөл, мэдээлэлд хяналт хийж, алдаатай, зөрүүтэй оруулсан мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Газрын нэгдмэл сангийн цахим систем	Газрын нэгдмэл сангийн цахим систем	Газрын нэгдмэл сангийн цахим системийн мэдээлэл засварлагдсан байна.	Газрын кадастрын мэдээллийн санд гэрээний хугацаа сунгуулж засварлах 15, хувийн хэрэгт бүрдэл хангахгүй хавсралт хэсэгт буруу оруулсанг засварлан зөвөөр оруулсан 156 нэгж талбар, гэрээний төлөв өөрчлүүлсэн 20 нэгж талбаруудыг газрын нэгдмэл сангийн цахим системд засварлагдсан.	100
2.1.8.11	Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчилтэй нэгж талбарын давхаргад хяналт хийж зөрчил арилсан мэдээллийг шинэчлэх, одоо байгаа болон шинээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо	Газрын кадастрын мэдээллийн систем	Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна.	Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчлийг арилгасан регистр засварлуулсан 5 нэгж талбар мэдээлэл буруу орсон 4 нэгж талбаруудыг иргэдээс ирсэн хүсэлтийг үндэслэн суурин судалгаа хийж газрын кадастрын мэдээллийн санд зөвөөр оруулж баталгаажуулсан. Сумдын Газрын даамалуудаас газрын кадастрын мэдээллийн санд буруу зөрүү орсон зөрчил аргилгуулах судалгааг гарган албан хүсэлтийн дагуу ГЗБГЗЗЕГазарт хүргүүлэх ажил хийгдэж байна.	100

2.1.9	Салбарын хэмжээнд сүлжээ, техник, програм хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах	Үйл ажиллагаа, урсгал төсөв, хөрөнгө оруулалт	Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа	Байгууллагын дотоод сүлжээ домэйн удирдлагын системд холбогдсон. 21 аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. Мэдээллийн аюулгүй байдлын газрын Төрийн хамгаалагдсан нэгдсэн сүлжээнд холбогдсон. Байгууллага, нийслэл, 21 аймаг, 345 цэг /сум, суурин, GNSS БАС/ интернэтийн сүлжээнд холбогдсон.	Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.		
2.1.9.1	Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах	Үйл ажиллагаа	Байгууллагын сүлжээний төхөөрөмж болон Газрын даамлуудын VPN тусгаарласан сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байдал	Аймаг, сумд интернэтийн сүлжээнд холбогдсон.	Эхний хагас жилд: Нийт сумдын Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын төхөөрөмж (Гэр интернэт)-ийг шинэчлэх ажлыг зохион байгуулаж, хэвийн ажиллагаанд оруулсан байна. Жилийн эцэст: Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний	Аймгийн байнгын ажиллагаатай хиймэл дагуулын мэдээ хүлээн авах GNSS SUA-1, станц болон газрын даамлуудын ашиглаж байгаа VPN тусгаарласан сүлжээ хэвийн. Албанд ашиглагдаж буй VPN-сүлжээний 13 төхөөрөмжийг 2024.01.19-ны өдрийн 1/161 тоот албан бичгийн дагуу 2024.02.01 өдөр шинэчлэн тохиоргоо хийж даамлуудын хэвийн ажиллах нөхцөл боломжоор ханган ажилласан. Төхөөрөмжийн тохиргоо алдагдах, устсан тохиолдолд тухай бүр арга хэмжээ авч тохиргоог хийж ажилласан. Төрийн байгууллагын цахим шуудан "mail.gov.mn", "ABLE", "erp.e-mongolia.mn"-г зэрэг цахим системүүдэд 24 албан хаагчдыг бүртгэж бүх алба хаагчид ашиглаж төрийн байгууллагуудтай	100

					аюулгүй, хэвийн ажиллагааг хангасан байна.	холбогдож албан бичиг тоот солилцох хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.	
2.1.9.2	Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах	Үйл ажиллагаа	Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа	Асуудал гарсан тухай бүрд техник засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж хэвийн ажиллагааг хангасан. Байгууллагад хэрэглэгдэж буй бусад техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, ажиллагааг ханган ажилласан.	- Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна. - Байгууллагад хэрэглэгдэж буй хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан байна.	Компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжүүдийн эвдрэл гэмтэл, хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд засвар үйлчилгээ хийж ажиллаж байна. 28 компьютерыг Техник хангамжийн картын бүртгэлд бүртгэн авсан. Байгууллагад ашиглаж буй хэвлэх хувьлах 18ш тоног төхөөрөмж болон даамал, мэргэжилтнүүдийн хэрэглэгдэж буй 28ш техник, 3 төрлийн программ хангамж /Autocad, arcGis, QGis/ 4төрлийн систем /Газрын удирдлагын нэгдсэн систем, Able, erp.e-mongolia, mle.mn/ дээр хэвийн ажиллах нөхцөл боломжоор хангасан. Жилийн эцсийн байдлаар 5 төрлийн хэвлэх хувьлах төхөөрөмжийг, давтамжтайгаар 40 удаа засвар үйлчилгээ хийж 28ш компьютерийг эвдрэлт гэмтлийг давтамжтайгаар 45-50 удаа форатлаж, сэлбэж засварлаж ажилласан байна. Мөн хяналт шалгалттай холбоотойгоор байгууллагад 4ш түргэн сканер авч мэргэжилтнүүдэд ашиглах заавар зөвлөгөө өгч компьютер таниулж өгсөн байна. Баруун-Урт сумын нэгдсэн үйлчилгээний төвийн байранд байрлах киоск машины эвдрэл гэмтэл, сүлжээ доголдол үүсэх үед тухай бүрд нь очиж засварлаж хэвийн ажиллуулж байна.	100
2.1.10	Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд шаардлагатай веб хуудас, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх хэрэглээнд нэвтрүүлэх	Үйл ажиллагаа, урсгал төсөв	3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт	8 веб хуудас хэрэглээнд гаргасан.	3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.		

2.1.10.1	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геопортал)-ийн дэд санг стандартын дагуу бүрдүүлэх	Үйл ажиллагаа	Дэд сан бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн тоо	2023 онд Геоорталд дэд сан бүрээр өгөгдөл бүрдүүлсэн.	Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрдүүлсэн байрлалд суурилсан мэдээллийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геоортал)-д 18 дэд сангийн стандартын дагуу баяжуулж, бүрдүүлсэн байна.	Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хөрөнгөөр хийгдсэн нийт 20 бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн зургийг MNS6702:2017 стандартын дагуу гүйцэтгүүлэн шалгаж хүлээн авч байр зүйн мэдээллийн санд барилга 9ш, байгууламж 3ш, Авто зам 156.6м буюу 1092.2м2, явган зам 1032.7м, ногоон байгууламж 1790.95м2, цахилгаан дамжуулах тулгуур шон 181ш, гэрэлтүүлгийн шон 994ш, цамхагт гэрэл 141ш, саравч 4ш, бетонон талбай 20730.1848м2, ариутгах татуургын шугам 823.5767м, ариутгах татуургын худаг 47ш, дулааны шугам 1880.9619м, дулааны худаг 25ш, цэвэр ус дамжуулах шугам 955.64м, цэврийн худаг 4ш, газар доорх өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам 2746.7911м, газар дээрх өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам 24918.66м, газар доорх нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам 1959.7594м, цахилгааны худаг 12ш, хувьсгуур 12ш, газар доорх шилэн кабель 209378.11м, газар доорх холбооны шугам 1036.0379м, холбооны худаг 21ш-ийг тус тус бүрдүүлсэн байна. Түүнчлэн тухай бүр байр зүйн дэвсгэр зургийн мэдээллийн санг баяжуулан хүсэлт ирүүлсэн 45 ААНБ-ыг шаардлагатай байр зүйн дэвсгэр зургаар ханган ажилласан байна.	100
2.1.12	Салбарын архивын баримтаар хэрэглэгчдэд үйлчлэх	Үйл ажиллагаа	Цаасан болон цахим баримтын үйлчилгээ	1685 хадгаламжийн нэгжийн баримтаар үйлчилгээ үзүүлсэн.	Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.		
2.1.12.1	Архивын баримтаар байгууллага, иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох	Үйл ажиллагаа	Ирүүлсэн хүсэлтийн дагуу үзүүлсэн үйлчилгээний тоо, төрөл	2023 онд архивын 12 хадгаламжийн нэгжийн баримтаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэн болон байгууллагын дотоодын үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлсэн.	Ирүүлсэн хүсэлтийн дагуу цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.	Архивын баримтаар байгууллага, аж ахуй нэгж, иргэн болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд захирамж, нэгж талбарын хувийн хэрэг болон шаардлагатай баримтыг иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Мөн Авлигатай тэмцэх газар шаардлагатай баримт бичгийн хуулбарыг эх хувьтай тулган баталгаажуулалт хийж 14 хувийн хэргийн 1350 хуудас материалыг “ХУУЛБАР ҮНЭН” тэмдэг даран хүлээлгэн өгсөн.	100

2.1.13	Төрийн архивын стандарт орчныг сайжруулах	Үйл ажиллагаа	Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа	-	Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.		
2.1.13.1	Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах талаар санал тавьж шийдвэрлүүлэх	Үйл ажиллагаа	Саналын тоо	Жил бүр архивын стандарт орчныг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг.	Эхний хагас жилд: Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын тооцоо гарган удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Жилийн эцэст: Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авсан байна.	Архивт хадгаламжийн санг зориулалтын төмөр буюу 4 хос нягтруулсан шүүгээгээр тоноглож, архивын самбар, галын самбар, чийг дулаан хэмжигч, чийгшүүлэгч, галын хэрэгсэл, цонхыг битүүлж гадна талаас блокоор битүүлж хар хөшиг хийх зэрэг ажлууд хийгдсэн байгаа. Одоо байгаа шүүгээ тавиур хүрэлцээ муу байгаа ч өрөөний хувьд зай талбай бага стандарт бус учир ахин шүүгээ тавиур тавих боломжгүй нөхцөл байдалтай байна.	100
2.1.14	Геодезийн хэмжилтийн багаж баталгаажуулалтын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах	Үйл ажиллагаа	Баталгаажуулсан багажны тоо	2022 онд улсын хэмжээнд 2325 багаж баталгаажуулсан.	2023 онд улсын хэмжээнд 1540 багажийг баталгаажуулсан байна.		
2.1.14.1	Аймгийн ГХБХБГ-т хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах	Үйл ажиллагаа	Багажны тоо	2023 онд аймгийн ГХБХБГ-т хэрэглэж байгаа нийт багаж баталгаажуулалт хийлгэсэн.	2023 онд баталгаажуулалт хийлгэсэн хугацаанд, бүх багажуудыг бүрэн хамруулсан байна.	Trimble R-4 маркийн 5408455507, 5413461106 хувийн дугаартай GNSS-ийн хүлээн авагч /base, rover/, Sokkia SET530R маркийн 145315 хувийн дугаартай электрон тахеометр, БХБХэлтсийн Sokkia B40A маркийн WS074715 хувийн дугаартай автомат нивелир, South ET-02 маркийн T159128 хувийн	100

						дугаартай электрон тахеометр багажны баталгаажилтыг ГЗБГЗЗГ-ын Хэмжил зүйн лабораторид 2024 оны 10-р сарын 17-ний өдөр хийлгэж 0030947, 0030948, 0030949, 0030950, 0030951 тоот гэрчилгээ авсан.	
2.1.15	Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах	Үйл ажиллагаа	Иргэн, хуулийн этгээдийн тоо		Эрсдэл үүсэх магадлалыг бууруулсан байна		
2.1.15.1	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Үйл ажиллагаа	Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо	-	Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Тайлант хугацаанд газрын харилцааны хяналтын чиглэлээр иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 13 өргөдөл хүсэлт, гомдлын дагуу хяналт хийж хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлж 1 гомдол хяналтад байна. Хугацаа хоцорсон өргөдөл байхгүй болно. 1.Глобал интележинт солюшн ХХК-иас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч ГЗБГЗЗЕГ-т нөхөн бүрдүүлэлтэд оруулах эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлж өргөдөл гаргагч Глобал интележинт солюшн ХХК-д газрын даргын 1/108 тоот “Хариу хүргүүлэх тухай” тоот албан бичгээр хариуг хүргүүллээ. 2.Онгон сумын 5 дугаар багийн иргэн Г.Болорцэцэгээс ирүүлсэн гомдлын дагуу Ongon сумын Засаг даргын тамгын газарт 1/199 “Нотлох баримт ирүүлэх тухай” албан бичгийг хүргүүлэн холбогдох бичиг баримтыг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлж гомдлыг хянах ажлыг хийлээ. Гомдлыг шалгаж гомдол гаргагч иргэн Г.Болорцэцэгт 1/214 тоот “Хариу хүргүүлэх тухай” албан бичгээр гомдлын хариуг хүргүүллээ. Мөн иргэн Г.Болорцэцэгийн гомдолтой холбогдуулан Ongon сумын Засаг даргад 1/220 тоот “Хууль тогтоомжийн	100

